



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн дагуу 8 чиглэлээр тайлан бэлтгэж, Иргэний зөвлөл, оршин суугчдад тайлагнаж байна. Үүнд:

Нэг: Төсвийн төсөл, зарцуулалт, үйл ажиллагааны аудитын болон санхүүгийн тайлан;

Цагдаагийн газрын 2019 оны нийт төсөв 2.333.164.600 /хоёр тэрбум гурван зуун гучин гурван сая нэг зуун жаран дөрвөн мянга зургаан зуун/ төгрөг бөгөөд Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журмын дагуу зарцуулж, санхүүгийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг ханган иргэдийн мэдээ мэдээлэл авах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллалаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ТӨСӨВ, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ

| д/д | Зардлын төрөл | 2019 оны төсөв | Төсвийн гүйцэтгэл | Зарцуулалтын хувь |
|----------|---------------------------------------|----------------------|----------------------|-------------------|
| 1 | Цалингийн зардал | 1.963.990.100 | 1.963.935.526 | 99.9% |
| 2 | Тогтмол зардал | 98.115.600 | 98.084.713 | 99.9% |
| 4 | Гэрэл цахилгаан | 19.076.000 | 19.071.000 | 100% |
| 5 | Түлш халаалт | 74.521.700 | 74.521.243 | 99.9% |
| 6 | Цэвэр, бохир ус | 4.522.900 | 4.494.470 | 99.3% |
| 7 | Бараа, ажил үйлчилгээний бусад зардал | 271.058.900 | 273.955.706 | 101.0% |
| 8 | Нийт дүн | 2.333.164.600 | 2.335.975.945 | 100.1% |

Хоёр: Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилт, түүний үр дүн;

2.1 Хяналтын камерын тусламжтайгаар 1552 хэрэг, зөрчил илрүүлэн шалгаж, шийдвэрлэсэн.



2.2. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас тус Цагдаагийн газарт ЗИЛ-131 маркийн тээврийн хэрэгсэл, бэлэн бус торгуулийн машин, хэвлэгч, таблет, станц, тандагч багаж, драйгер зэрэг техник хэрэгслийг олгосон.



2.3. Алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор хэсгийн төлөөлөгч, эргүүлийн цагдаа, цагдаа-зохицуулагч нарыг энгэрийн камераар бүрэн хангасан.



2.4. Хэсгийн төлөөлөгч нарын ажлын байрыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулснаар албаны шуурхай байдал хангагдаж, алба хаагчид мэдээ, мэдээлэл шуурхай авах, бүртгэх, ашиглах, солилцох урсгал нэмэгдсэн.



2.5. Цагдаагийн газрын дарга, сумын Засаг дарга, Хэсгийн төлөөлөгч нарын хамтарсан “Гурвалсан гэрээ”-ний дагуу Бугат сумын Засаг дарга Тойота Приус-10 маркийн тээврийн хэрэгсэл, Сагсай, Ногооннуур, Алтай сумын Засаг дарга нар мотоцикл олгов.



Мөн Ногооннуур сумын удирдлагууд орон нутгийн хөрөнгө оруулалтаар Тавалтайн хавцалд замын хөдөлгөөний хяналтын постыг барьж ашиглалтанд оруулсан.



2.6. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 400 метр газрыг хамгаалалтанд авах хайс хашааг хийлгэж ашигласнаар нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрүүд, нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтыг бага хүн хүчээр, оновчтой зохион байгуулахад ач холбогдолтой боллоо.



2.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор үйл ажиллагаандаа “LED” дэлгэцийг ашиглаж байна.



Гурав: Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх ажилтай холбоотой мэдээлэл;

3.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргийн талаарх 550, зөрчлийн талаарх 2535, нийт 3074 гомдол, мэдээлэл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба гомдол мэдээллийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 16.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Үүнээс гэмт хэргийн талаарх 124 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, 413 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 2 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэн хариу өгч ажиллалаа.

Дөрөв: Цагдаагийн алба хаагчийн сургалт, сахилга, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээлэл;

4.1. Цагдаагийн газрын даргын 2019 оны А/14 дүгээр тушаалаар “Албаны сургалт явуулах баг байгуулж, сургалтын төлөвлөгөө, хуваарь”-ийг баталж хэрэгжилтийг хангуулсан бөгөөд зохион байгуулсан нийт 60 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 7000 алба хаагчийг хамруулан алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв.



- Сургалтанд хамрагдсан алба хаагчийн тоог өнгөрсөн жилтэй харьцуулахад 2043 алба хаагч буюу 41.2 хувиар нэмэгдсэн.

4.2. Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний нэгдсэн сургалтыг 4 удаа зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 48 сургагч багшийн 52 сэдвийн хүрээнд удирдан зохион байгуулсан 38 цагийн танхим болон дадлагын сургалтанд 5000 гаруй алба хаагч хамрагдсан.



4.3. Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс болон бүсийн хэмжээнд зохион байгуулсан сургалтанд хамрагдсан 25 алба хаагчид давхардсан тоогоор 800 гаруй алба хаагчдад сургалт зохион байгуулсан нь сургалтыг хүртээмжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой боллоо.



4.4. “Хэсгийн төлөөлөгч нарын нэгдсэн сургалт”-ыг сар бүр, “Сум дундын бүс”-ийн сургалтыг Алтай суманд тус тус зохион байгуулснаар хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх нөлөөлөв.



4.5. Аймгийн шүүх, Прокурорын газартай хамтарсан сургалт, зөвлөгөөнийг 4 удаа зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нэгдсэн ойлголттой боллоо.



4.6. “Удирдах ажилтны манлайлал, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд миний оролцоо”, “Сахилга, ёс зүйн зөрчлийг бууруулахад алба хаагчийн оролцоо” сэдэвт эссе бичлэгийн уралдаан, “Шилдэг ахлах ажилтан-2019”, “Шилдэг ахлагч-2019”, “Шилдэг хэсгийн төлөөлөгч-2019” зэрэг ур чадварын уралдаан тэмцээн, “Хорт зуршлаас татгалзцгаая” сэдэвт жүжигчилсэн үзүүлбэрүүдийг тус тус зохион байгууллаа.



Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн Цагдаагийн байгууллагуудын “Ахлах мөрдөгч нарын ажил мэргэжил, ур чадварын тэмцээн”-д Хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Тунгышбай тэргүүн байр, Шуурхай удирдлагын тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Хайырлыс гутгаар байрыг шалгарч өндөр амжилт гаргав.



4.7. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Төрийн албаны сахилга хариуцлага дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллав.

Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 20 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан ба сахилга, ёс зүйн зөрчлийн 12 буюу 60 хувийг дотоод хяналтаар, 8 буюу 40 хувийг гадны хяналтаар илрүүлсэн бөгөөд дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 9 зөрчил буюу 75 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын 14 буюу 70 хувийг офицер, 6 буюу 30 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.

4.8. Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний сахилга хариуцлагын зөвлөгөөнийг 3 удаа, офицер, ахлагч бүрэлдэхүүний сахилга хариуцлагын зөвлөгөөнийг тус бүр 1 удаа, Цагдаагийн газрын тасаг, хэсгүүд сахилга хариуцлагын зөвлөгөөнийг сар бүр зохион байгуулсан ба давхардсан тоогоор 1000 гаруй алба хаагч хамрагдсан.




4.9. Алба хаагчидтай “Итгэлцлийн гэрээ” байгуулан хэрэгжилтийг хангуулснаар сахилга, ёс зүй, хариуцлага дээшлэхэд нөлөө үзүүлэв.



Тав: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал;

5.1. Аймгийн хэмжээнд 2019 онд 306 гэмт хэрэг бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн 31524 гэмт хэргийн 0.9 хувийг, баруун таван аймагт бүртгэгдсэн 1596 гэмт хэргийн 19.1 хувийг тус тус эзэлсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь:



2019 онд бүртгэгдсэн 306 гэмт хэргийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 12 хэргээр буюу 3.8 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарлаа.

ГЭМТ ХЭРЭГ 3.8 ХУВИАР БУУРСАН:



Хөнгөн 244, хүнд 62 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан.

ГЭМТ ХЭРГИЙН АНГИЛАЛ:



5.2. Гэмт хэргийн илрүүлэлтийг 74.2 хувьд хүргэсэн ба үүнийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 15.3 хувиар нэмэгдсэн эерэг үзүүлэлт гарсан.

ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ 15.3 ХУВИАР НЭМЭГДСЭН:



Илрүүлэлтийг бусад нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагатай харьцуулахад нэгдүгээрт эрэмбэлэгдсэн.

5.3. Нийт бүртгэгдэн гэмт хэргийн 40-50 хувийг эзэлдэг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 21 хэргээр буюу 19.2 хувиар, хулгайлах гэмт хэрэг 12 хэргээр буюу 17.9 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 10 хэргээр буюу 43.4 хувиар мөн хүүхэд оролцсон гэмт хэрэг 7 хэргээр буюу 31.8 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 2 хэргээр буюу 6 хувиар, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 1.2, хувиар тус тус буурсан.

ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН БУУРАЛТ:



5.4. Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 6292 алба хаагч 50.336 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Цагдаагийн газрын даргын 2019 оны А/07, А/69 дүгээр тушаалаар эргүүлийн нэгдсэн байршилтыг шинэчлэн баталж, эргүүлийг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, хүн амын суурьшил, хөдөлгөөн ихтэй газруудад томилон ажиллуулснаар зөрчлийн илрүүлэлт 3386 зөрчил буюу 23.9 хувиар өссөн нь гэмт хэргийг зөрчлийн шатан илрүүлэх ажил сайжирсныг харуулж байна.

ЗӨРЧЛИЙН ИЛРҮҮЛЭЛТ 23.9 ХУВИАР НЭМЭГДСЭН:



Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр 24 хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулсан ба хэсэгчилсэн арга хэмжээ болон нийтийн хэв журам хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан хяналт шалгалтын үр дүнд нийт 14146 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 13382 хүнд 577.510.000 төгрөгний торгуулийн шийтгэл оногдуулав.




Тухайлбал:

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийн илрүүлэлтийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 126 зөрчил буюу 42,5 хувиар, эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 42 зөрчил буюу 35.5 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Мөн цагдаагийн газрын алба хаагчид согтууруулах ундаа хэрэглэсний улмаас хаана байгаага болон очих газраа мэдэхгүй болсон 223, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй 294, нийт 517 хүний амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалав.

Нийт **517** хүний амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалав:



Согтууруулах ундаа хэрэглэсний улмаас хаана байгаага болон очих газраа мэдэхгүй болсон

Гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй

■ 2019 он

5.5. Сумдад бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх мэдээлэл:

СУМДАД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ:

| № | Сум, тосгоны нэр | 2018 он | 2019 он | Харьцуулалт өссөн, буурсан |
|----|------------------|---------|---------|------------------------------------|
| 1 | Алтай | 6 | 13 | 7 хэргээр буюу 53.8 хувиар өссөн |
| 2 | Алтанцөгц | 3 | 7 | 4 хэргээр буюу 57.1 хувиар өссөн |
| 3 | Баяннуур | 18 | 13 | 5 хэргээр буюу 27.7 хувиар буурсан |
| 4 | Булган | 5 | 6 | 1 хэргээр буюу 16.6 хувиар өссөн |
| 5 | Буянт | 12 | 8 | 4 хэргээр буюу 33.3 хувиар буурсан |
| 6 | Бугат | 17 | 14 | 3 хэргээр буюу 17.6 хувиар буурсан |
| 7 | Дэлүүн | 7 | 5 | 2 хэргээр буюу 28.5 хувиар буурсан |
| 8 | Ногооннуур | 26 | 21 | 5 хэргээр буюу 19.2 хувиар буурсан |
| 9 | Сагсай | 11 | 7 | 4 хэргээр буюу 36.3 хувиар буурсан |
| 10 | Толбо | 10 | 7 | 3 хэргээр буюу 30.0 хувиар буурсан |
| 11 | Улаанхус | 10 | 12 | 2 хэргээр буюу 16.6 хувиар өссөн |
| 12 | Цэнгэл | 18 | 26 | 8 хэргээр буюу 30.7 хувиар өссөн |
| 13 | Өлгий | 175 | 167 | 8 хэргээр буюу 4.5 хувиар буурсан |

5.6. Тус аймагт зохион байгуулагдсан Алтай таван богд уулын тэнгэрийг тайх төрийн ёслолын үйл ажиллагаа, баруун бүсийн зуны уралдаан, “Бүргэдийн баяр” Сагсай, Алтай, Бугат сумдын 60 жилийн ой зэрэг баяр наадам, урлаг, соёлын болон бусад төрлийн 31 удаагийн арга хэмжээний хамгаалалтыг төлөвлөгөө, зураглалын дагуу гэмт хэрэг, зөрчилгүй өнгөрүүлсэн.





5.7. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол-5, хөтөлбөр-2, аймгийн Засаг даргын захирамж 2, нийт 9 шийдвэр гаргуулан хэрэгжилтийг хангуулсан.



5.8. Мөн эрүү болон хэв журмын нөхцөл байдалд уялдуулан нийт 24 удаа хэсэгчилсэн арга хэмжээ, 25 удаагийн нэгдсэн үзлэг шалгалт, 102 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгаа, 16 удаа уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, 12 удаа өдөрлөг, 5 удаа уралдаан, тэмцээн зэргийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулсан бөгөөд нийт 13493 хүн хамрагдсан.





5.9. Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 154 мэдэгдэл, 117 шаардлага хүргүүлж биелэлтийг 100 хувь хангуулсан.


5.10. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 136 удаа мэдээ мэдээлэл өгч, цахим орчинд 237 төрлийн мэдээ мэдээлэл байршуулж, 52 төрлийн 19257 ширхэг гарын авлага, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.

Зургаа: Нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийн хэрэгжилт;

6.1. Цагдаагийн газраас нийт 240 гаруй төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажилласан.



6.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 33 байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион байгууллаа.





6.3. Алба хаагчдыг аймгийн төв Өлгий суманд үйл ажиллагаа явуулдаг 76 аж ахуйн нэгж байгууллагыг Цагдаагийн газрын даргын 2019 оны А/02 дугаар тушаалаар хариуцуулж давхардсан тоогоор 315 аж ахуйн нэгж байгууллагаас зохион байгуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав.

Долоо: Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны бодлогын хэрэгжилт;

7.1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2019 оны 60, 62 дугаар тогтоолоор “Эрүүл зан үйлийг дэмжсэн архидалтгүй аймаг-Баян-Өлгий”, “Соёлтой жолооч” зэрэг дэд хөтөлбөрийг тус тус батлуулан, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу тодорхой цогц ажил, арга хэмжээг зохион байгуулсны үр дүнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдсэн, гэмт хэрэг буурсан, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн зэрэг эерэг өөрчлөлтүүд гарлаа.

7.2. “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Хил дамнасан мал хулгайлах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах нь”, “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн салбар дундын сургалт, зөвлөгөөн, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь”, “Хүүхдийг эерэг хүмүүжлийн аргаар хүмүүжүүлэх нь”, “Сайныг түгээе” хэлэлцүүлэг, “Хүчирхийлэлд үгүй гэж хэлье”, “Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэлтэй хамтдаа тэмцье” дэвжээ тэмцээн, “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нь” аяныг тус тус зохион байгуулсан.

7.3. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар, хүртээмж, орчинг сайжруулах зорилгоор Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын орон нутгийн салбарын дэмжлэгтэйгээр сургалтын танхимыг орчин үеийн стандарт нийцүүлэн тохижуулсан.



Найм: Бусад шаардлагатай асуудлаар;

7.1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамжийн дагуу зохион байгуулагдсан Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт 92 төрлийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бэлтгэл ажлыг ханган 97.3 хувьтай хамрагдав.



7.2. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 1 алба хаагч Төрийн одон медалиар, 18 алба хаагч цагдаагийн цолоор, 46 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын шагналаар тус тус шагнагдсан.



7.3. Аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 5 алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг олгосон.

7.4. Цагдаагийн газрын дундын сангийн журмын дагуу нийт 61 алба хаагчдад 5.650.000 төгрөгний мөнгөн хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлээ.



7.5. Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан 173 удаагийн ажил, арга хэмжээнд давхардсан тоогоор 21949 алба хаагчийг хамрууллаа.



7.6. “Эрүүл-цагдаа” хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 600 гаруй алба хаагчийг эрүүл мэндийн үнэ төлбөргүй үзлэг, сургалтанд хамруулсан.

“Эрүүл-цагдаа” хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 600 гаруй алба хаагчийг эрүүл мэндийн үнэ төлбөргүй үзлэг, сургалтанд хамруулсан.




7.7. “Сар шинэ”, “Наурыз”-ын баяр, Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулж, “Ахмадын сан”-д 500.000 төгрөг хандивлав.



Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан “Ахмад, дунд, залуу үеийн гурвалсан холбоог сайжруулах нь” уулзалтыг өргөн хүрээнд зохион байгууллаа.



7.8. “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд ахмад ажилтнуудтай 13 удаагийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулсан.



7.9. Алба хаагчдын оюуны хэрэгцээг хангах, мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Төв номын сантай “Зөөврийн номын сан ажиллуулах гэрээ” байгуулан хамтран ажилласан.



7.10. Байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Сэтгэлийн үг”, “Үлгэр жишээч гэр бүл”, “Миний түүх” нэвтрүүлгийг бэлтгэн иргэд, олон нийтэд сурталчлав.

7.11. Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргын өргөтгөсөн зөвлөл, Иргэний зөвлөл, Өлгий, Ногооннуур, Улаанхус, Дэлүүн сумдын иргэдэд тайлагнав.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАВ.





7.12. Цагдаагийн газраас 2018 онд хэрэгжүүлсэн, ажил, арга хэмжээ, гаргасан ололт амжилт, тэргүүн туршлагыг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор жил бүр эрхлэн гаргадаг “ӨЛГИЙ-ЦАГДАА” сэтгүүлийн 5 дахь дугаарыг гаргаж, иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй хүргэв.


**ЦАГДААГИЙН ГАЗРААС ЭРХЛЭН
ГАРГАСАН СЭТГҮҮЛ**



**Мэдээлэл- 82
Зураг- 215
Хүснэгт- 14**

7.13. Цагдаагийн газрын баг, тамирчид тив дэлхий, улс, бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан тэмцээнд өндөр амжилт гаргасан. Тухайлбал:

Цагдаагийн дэд ахлагч Х.Бекнур БНХАУ-ын Сычуань мужийн Чеэндү хотод зохион байгуулагдсан Дэлхийн цагдаа, галын олимпид Монгол Улсын цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нэрийг дэлхийн тавцанд өндөрт өргөж, каратегийн - 90 кг жинд алтан медаль, Боксын 90 кг жинд мөнгөн медаль хүртэн өндөр амжилт үзүүлсэн.






Баян-Өлгий аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион явагдсан “Спортын цогцолбор” тэмцээнд тус Цагдаагийн газрын баг, тамирчид амжилттай оролцож, 3-р байранд шалгаран “Өргөмжлөл”, мөнгөн медалиар шагнагдав.

Мөн Цагдаагийн дэд ахлагч Э.Гантөмөр "Мөсөн сур"-ын Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож спортын мастерын болзол хангаж, цагдаагийн хошууч Н.Дарханбаяр Мөрдөн байцаах албаны нэрэмжит "Уулын унадаг дугуй"-н тэмцээнд тэргүүн баяр, цагдаагийн хошууч Т.Ердос аймгийн 2019 оны аварга шалгаруулах “Ширээний теннис”-ийн багийн төрөлд тэргүүн байранд тус тус шалгарав.




7.14. Албаараа бахархах, бүтээлч сэтгэлгээ, байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Алдарын булан”-г шинээр барьж, иргэдийг хүлээж авах танхим, сургалтын танхимыг шинэчилж, “Ажиллах орчноо сайжруулъя” болзолт уралдааныг зохион байгуулан иргэдэд таатай орчинд үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүллээ.

Иргэдийг хүлээж авах танхимыг шинэчлэв.



7.16. Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байранд иж бүрэн засвар үйлчилгээ хийж, тохижуулав.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд иж бүрэн засвар үйлчилгээ хийсэн.



7.17. Өмнөд Судан Улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагааны VIII ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэсэн тус Цагдаагийн газрын Холбоо, мэдээллийн инженер, цагдаагийн ахмад Т.Ардакелди, Дотоодын цэргийн тусгай салааны харуулчин, ахлагч Ш.Сүх нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР